

PLITONIT PLITOFLEX MONTAGE Маш өндөр барьцалдалттай угсралтын цавуу



280

- ✓ Сайжруулсан силикон полимер
- ✓ 350 кг/м² – анхны ачаалал
- ✓ Тасрах хүртэлх суналт — 200% хүртэл
- ✓ Анхны хальс тогтох хугацаа — 30 минут
- ✓ Гадна болон дотор орчинд хэрэглэнэ

PLITONIT

Plitonit
Deutsche
Qualität

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН

Бүх төрлийн материалыг дотор болон гадна орчинд наахад тохиромжтой

Зааврыг өөр хэлээр татах/
Download the manual in another language
kz | az | uz | tj | kg | tm | am | ge | mn

Хэрэглээний хүрээ

Гадна болон дотор орчинд дараах элементүүдийг нааж угсрахад хэрэглэнэ. Үүнд: Ханын хавтан, шалны хөвөө (плинтус), босго, усны тосгуур хоолой, сантехникийн холбох хэрэгсэл (фитинг), толь болон хавтангийн өнгөлгөөний элементүүд (далд люк, дэлгэц, тавцан г.м) багтана. Мөн даацын бүс бүтээц, элементүүдийг угсрах (хөнгөн тавилга, тоног төхөөрөмжийг сул эрдэс суурьтай гадаргуу дээр дүүжилж тогтоох) үед химийн анкерийн оронд ашиглах боломжтой.

Наах гадаргуугийн төрлүүд	Ханын гадаргуу
Керамогранит	+
Керамик хавтан	+
Байгалийн чулуу (цууны хүчилд тэсвэртэй)	+
Хиймэл чулуу	+
Шил (үүнд толь багтана)	+
Хуванцар	+
Мод / фанер / ДСП / OSB гэх мэт	+
Металл (үүнд хөнгөн цагаан багтана)	+
Бетон болон бусад эрдэс материалууд	+
Орг шил/ поликарбонат	-

*Хавтан наах болон «дулаан шал»-ны системийг хамтад нь угсрах технологийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг plitonit.ru вэбсайтаас авах боломжтой.

Техник үзүүлэлтүүд

Өнгө	Цагаан
Суурь материал	STP полимер
Цавууны хамгийн бага зузаан	2-3 мм
Ашиглалтын үеийн температурын горим	+5°C-ээс +40°C хүртэл
Ашиглалтын үеийн температурын горим	от -40°C -ээс +90°C хүртэл
Нягт	1,58 ± 0,03 г/см ³
Тасрах хүртэлх суналт	200%

Гадаргууг бэлтгэх

1	Цавуу түрхэхээр төлөвлөж буй гадаргууг (сүүрийг) шороо, тоосноос цэвэрлэж, хуурч ховхорсон хэсгүүдийг арилган, тосгүйжүүлж, хатаасан байх шаардлагатай.
---	---

Ажил гүйцэтгэх дараалал

1	Картрижийн үзүүрийг хайчилж, цоргыг эргүүлэн шурагдан суулгана.
2	Шүүрний хошууг гаргах заадсын хэмжээнд тохируулан, гэхдээ голч нь 3 мм-ээс багагүй байхаар налуулан зүснэ.
3	Картриджийг шахагч гар буунд (пистолет) байрлуулна. Гар бууг (пистолет) сонгохдоо бүтээгдэхүүний зууралдмал чанарыг анхаарна уу.
4	Агаарын урсгалыг чөлөөтэй нэвтрүүлэх үүднээс наах гадаргуугийн аль нэг дээр цавууг хооронд нь 10–15 см-ийн зайтай зурвас (зураас) хэлбэрээр түрхэнэ.
5	Нааж буй гадаргууг бие биед нь шахаж өгнө.

Шинэ заадлыг хусуураар тэгшлэхийг зөвшөөрнө. Хатаагүй материалыг уусгагчаар, харин хатсан материалыг зөвхөн механик аргаар цэвэрлэнэ

Ажлын нөхцөл

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 3 хоногт агаарын температур, сүүрийн болон хавтангийн температур +5 °C-аас +30 °C хооронд байх нь зохимжтой.

Анхааруулга

Угсарсан холболтын эдэлгээний хугацаа нь ажлын гүйцэтгэл зөв байхаас хамаарна. Цавууг хатаж, бэхжих хугацаанд түүнд хүрэхээс зайлсхий. Хөлдсөн гадаргуу дээр хэрэглэхээс зайлсхий. Хатах явцад спирт болон уусгагч бодисууд хүргэхээс зайлсхий. Байнга усан доор байх газарт бүү хэрэглэ. Энэхүү бүтээгдэхүүн нь үс (тогтмол бүс хүрэлцэх), алифатын бүлгийн уусгагч, минерал тос, тосолгооны бодис, сулруулсан органик хүчил болон шүлтэд өндөр тэсвэртэй чанартай. Үнэрт уусгагч, өтгөрүүлсэн хүчил болон хлоржуулсан нүүрстөрөгчид тэсвэргүй.

Аюулгүй ажиллагаа

БОЛГООМЖТОЙ!

Залгихад хортой

Ажиллаж байхдаа бээлий, тусгай хувцас, нүдний хамгаалалт хэрэглээрэй.

Ажлын дараа гараа нүүрээ сайтар угаана.

ХЭРВЭЭ АРСАНД ХҮРСЭН бол их хэмжээний усаар зайлж, цочрол арилахгүй байвал эмчид хандаарай.

НҮДЭНД ХҮРСЭН ТОХИОЛДОЛД: Хэдэн минутын турш усаар болгоомжтой зайлж угаана. Хэрэв та контакт линз хэрэглэдэг бол үүнийг хийхэд хялбар бол авч, нүдээ үргэлжлүүлэн усаар сайтар зайлна. Хэрэв нүдийг цочрол арилахгүй бол эмчид хандана уу.

ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Орц, найрлага

STP полимер

Тээвэрлэлт ба хадгалалт

Механик гэмтлээс хамгаалах чадвартай хаалттай, тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Гадна бодис, хүр тунадас орохоос хамгаалсан нөхцөлд агуулахад үйлдвэрлэгчийн хаалттай савлагаатай нь хадгална. +5°C-ээс +25°C хэмд тээвэрлэж, хадгална. Бүтээгдэхүүний хадгалах хугацаа нь үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэлт, хадгалалтын горим болон энэхүү гарын авлагад заасан зааврыг мөрдсөн тохиолдолд үйлдвэрлэгч нь угсралтын цавууны чанар (үзүүлэлтүүд) өөрийн техникийн тодорхойлолтод бүрэн нийцэхийг баталгаажуулна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй.

ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ 8.579-2002 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна.

Материалын зарцуулалт.

280 мл нь 5 мм-ийн диаметртай 11 шугаман метр болно

ХЭРЭГЛЭГЧИЙН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

8 (800) 555 - 71 - 67

[www. plitonit.ru](http://www.plitonit.ru)

e-mail: info@mc-bauchemie.ru